



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/529

Мандалговь

Газар эзэмших эрхийг
шилжүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дахь заалт, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалт, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах байгууллагын албан тоотыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг, Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэр (5 дугаар цэцэрлэгийн баруун хойд талд Нарлаг-3-330)-т байршилтай Дундговь-Ус ОНӨААТҮГазар (РД:3427951)-ийн үйлчилгээ, гаражийн зориулалттай 2500 м.кв (0,25 га) газрыг Дундговь аймгийн хот тохижуулах газар орон нутгийн өмчит ААТҮГазар (РД:3434532)-т зориулалтаар нь шилжүүлж 24 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр, Дээрх байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг ГХБХБГазар, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав, Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2012 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн А/318 тоот захирамжийн 4 дэх хэсэг, мөн газар эзэмших 0209358 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

438010641